

ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Монгол Улс дахь олон улс судлал, олон улсын харилцааны суурь судалгааг дагнан хэрэгжүүлэгч мэргэжлийн ууган байгууллага болох ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс жил тутам эрхлэн гаргадаг “Олон улс судлал” сэтгүүлийн ээлжит 117 дахь дугаараа бид уншигч Таны гарт өргөн барьж байгаадаа баяртай байна.

“Олон улс судлал” сэтгүүл өдгөө уламжлалт цаасан суурьтайгаар хэвлэгдэхийн зэрэгцээ тогтмол цахим хувилбараар уншигч олонд хүрдэг билээ. Өнгөрсөн 2023 онд манай сэтгүүл DOAJ - Directory of Open Access Journals-д¹ бүртгүүлсэн тус хүрээлэнгийн хоёр дахь сэтгүүл болсон бөгөөд өдгөө 2024 оны байдлаар www.imori.ac.mn, www.mongoliajol.info/index.php/JIS цахим хуудаснаа буй нийт бүтээлийг 51 мянга гаруй удаа татан авч ашигласан тоон үзүүлэлттэй байгаа юм.

2024 онд манай сэтгүүлийн редакц гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэлд хөндлөнгийн хянан магадлааг тус бүр хоёр удаа хийж, энэ удаагийн дугаартаа найман өгүүлийг сонгон авч та бүхэнд хүргэж байна. Энэ удаагийн дугаарт Монгол Улс ба хөрш хоёр орны харилцаа, гадаад бодлого болон “гуравдагч хөрш”-ийн харилцаатай холбогдох асуудлаар эрдэм шинжилгээний ач холбогдолтой өгүүлүүд нийтлэгджээ. Тухайлбал, ОХУ-Украины мөргөлдөөн эхэлснээс

нэг жилийн дараа буюу 2023 оны 3 дугаар сард Оросын Холбооны Улс Гадаад бодлогын үзэл баримтлалаа шинэчлэн баталсан нь манай улсын гадаад орчинд өрнөсөн томоохон өөрчлөлтүүдийн нэг болсон юм. Энэ асуудлаар ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Адъяагийн Нямдолжингийн бичсэн “ОХУ-ын 2023 оны гадаад бодлогын шинэ үзэл баримтлалд хийсэн судалгаа” өгүүлийг онцолж байна. Тэрээр өгүүлэлдээ ОХУ-ын 2023 онд батлагдсан Гадаад бодлогын шинэ үзэл баримтлалын онцлогийг өмнөх 1993, 2000, 2008, 2013, 2016 оны үзэл баримтлалуудтай харьцуулах, шинээр дэвшүүлсэн үзэл, санаа, чиг хандлагийг Орос-Украины дайны нөхцөл байдлын хүрээнд судлахын сацуу тус шинэ үзэл баримтлалд Монгол Улсын талаар баримтлах бодлогыг тусгасан заалтыг шинжилж, хоёр орны харилцаанд учирч болзошгүй сорилтуудыг тодорхойлжээ.

Энэ удаагийн дугаарт ОХУ-ын гадаад, дотоод бодлогын асуудлаар дээрхээс гадна хоёр өгүүлэл багтсан нь мөн тус хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D) Авирмэдийн Даваасүрэнгийн “Монгол-Оросын худалдаанд гарч буй өөрчлөлтүүд ба тэдгээрийн зүй тогтол”, эрдэм шинжилгээний ажилтан Болдын

¹ DOAJ нь дэлхийн өнцөг булан бүрд гарч буй эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн (open access) -ийн албан ёсны бүртгэл бөгөөд чанартай агуулгуудыг нээлттэйгээр хүн бүрд хүргэх зорилготой олон улсын өргөн хүрээтэй санаачилга билээ. Одоогоор DOAJ бүртгэлд дэлхийн 133 орны 19603 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэлтэй байна. Дашрамд сонирхуулахад DOAJ-д Монгол Улсаас өнөөгийн байдлаар 7 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэгдсэн байгаа бөгөөд үүнээс 6 нь #MongoliaJOL платформын эрдэм шинжилгээний сэтгүүлүүд байна. <https://doaj.org/toc/2663-7871>

Хишигжаргалын “ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын бүс нутаг дахь түлш, эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” нар болно. “Монгол-Оросын худалдаанд гарч буй өөрчлөлтүүд ба тэдгээрийн зүй тогтол” өгүүлэлд сүүлийн гучин жилийн хугацаанд Монгол-Оросын худалдаанд гарсан өөрчлөлт, зүй тогтлыг хоёр улсын худалдааны статистик тайланд тулгуурлан шинжлэх замаар хоёр талын худалдааны тэнцвэргүй байдалд нөлөөлж буй объектив хүчин зүйлс, Монгол Улстай шууд залгаа хиллэдэг болон хиллэдэггүй ОХУ-ын субъектүүдтэй хийж байгаа худалдаан дахь харьцааны өөрчлөлтийг тодруулж өөрийн саналыг дэвшүүлсэн бол “ОХУ-ын Сибирь, Алс Дорнодын бүс нутаг дахь түлш, эрчим хүчний салбарын хөгжил, тулгамдсан асуудлууд” өгүүлэлд Монгол Улстай хил залгадаг ОХУ-ын хэсэг, тус улсын байгалийн нөөцийн ихэнх хэсэг төвлөрдөг Сибирь болон Алс Дорнодын бүс нутаг дахь эрчим хүчний салбарын нөхцөл байдал болон хөгжлийн явцад тулгарч буй асуудлууд, тэдгээрт ОХУ-ын зүгээс авч буй арга хэмжээг судлан шинжилсэн байна.

Үүнтэй зэрэгцэн манай улсын өмнөд хөрш БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны дотоодын хөгжлийн бодлого, тэдгээрт тулгарч буй сорилтуудыг шинжилсэн өгүүлэл энэ удаагийн дугаарт нийтлэгдсэн нь тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Мөнхөөгийн Эрдэнэбаярын “Өвөр Монголын аж үйлдвэрийн хөгжлийн сорилт, сургамж” өгүүлэл болно. Тус өгүүлэлд ӨМӨЗО нь байгалийн арвин нөөцийн давуу талд суурилсан хүнд үйлдвэрлэл бүхий аж үйлдвэрийн тогтолцоог хөгжүүлсэн ч

сүүлийн үед улс орнуудад тавигдаж буй нөөцийн хумигдал, ногоон хөгжлийн шаардлага зэрэг хүчин зүйлсийн улмаас уг салбарт шинэтгэл хийх, өрсөлдөх давуу талыг хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгамдаж буйг онцолж, тэдгээрт төр засгаас хэрхэн бодлогын түвшинд хариу арга хэмжээ авч байгааг шинжилж, манай улсад сургамж болох санааг дэвшүүлжээ.

Түүнчлэн энэ дугаарт манай улсын гадаад бодлогын “гуравдагч хөрш” орон судлалын асуудлаар дөрвөн өгүүллийг уншигч олонд хүргэж байна. Эхнийх нь ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Түвшинжаргалын Анударийн “Энэтхэг-Номхон далайд явуулж буй Британийн гадаад бодлого ба Монгол Улс” өгүүлэл болно. Тус өгүүлэлд зохиогч БРЕКСИТ-ээс хойш Британийн гадаад бодлогод гарсан өөрчлөлт хийгээд тус улс Энэтхэг-Номхон далайн бүс нутагт анхаарч буй шалтгааныг тодруулан, уг бодлогын Монгол Улс дахь тусгал, хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөвийг Британийн гадаад бодлогын болон хоёр талын харилцааны баримт бичгүүдэд үндэслэн тодорхойлсон байна. Мөн тус хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Дашдаваагийн Мягмар “БНСУ-ын экспортыг дэмжих тогтолцоо, Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц туршлага” өгүүлэлдээ Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Үйлдвэрлэл худалдаа, нөөцийн яам тэргүүтэй экспортыг дэмжих байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг шинжлэн, тус улсын экспортын хөгжилд төрийн байгууллагуудын

дэмжлэг чухал үүрэгтэй байдгийг дурдаж, Монгол Улсын зүгээс эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд экспортыг дэмжих төрийн байгууллагын үр ашигтай бүтцийг бүрдүүлэх шаардлагатай гэсэн саналыг дэвшүүлжээ.

2022 онд Япон Улс Үндэсний аюулгүй байдлын шинэ стратегиа баталсан тухайд тус салбарын эрдэм шинжилгээний ажилтан Баярсайханы Саранчимэг “Япон Улсын Үндэсний аюулгүй байдлын стратегийн шинэ хандлага, төлөв” өгүүлэлдээ уг баримт бичгийн шинэлэг талыг АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратегийн баримт бичиг, Япон-АНУ-ын аюулгүйн гэрээ, Батлан хамгаалах бодлогын баримт бичиг, Үндэсний аюулгүй байдлын стратегийн хүрээнд сүүлийн 10 жилийн хугацаанд хэрэгжиж ирсэн бодлого, үйл ажиллагаанд уялдуулан авч үзжээ.

Монгол Улсын нээлттэй, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд “оюун санааны хөрш” хэмээн тодорхойлдог Бүгд Найрамдах Энэтхэг Улстай хоёр талт харилцааг хөгжүүлдэг бөгөөд тус улс манай улстай “Иж бүрэн түншлэл”-ийн харилцаатай болсон дөрөв дэх улс билээ. Тус хүрээлэнгийн Гуравдагч хөрш орон судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан Энхбаатарын Мөнхзулын “Нарендра Модигийн үеийн Энэтхэгийн гадаад бодлого дахь Монгол Улс” өгүүлэлд Энэтхэг Улсын гадаад бодлогыг олон улсын харилцаан дахь хүчний тэнцвэрийн онолд тулгуурлан авч үзэж, Нарендра Модиг 2014 онд тус улсын Ерөнхий сайдаар сонгогдсоноос

хойш өнөөг хүртэл явуулж буй гадаад бодлого, түүний онцлог, тэргүүлэх чиглэл, Монгол Улсын талаарх байр суурийг шинжилжээ.

Түүнчлэн өдгөө дэлхий дахины монгол судлалд өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулж яваа бидний номын эрхэм нөхөр, Оросын Холбооны Улсын нэрт монголч эрдэмтэн, доктор, профессор Юрий Васильевич Кузьмины 70 насны ой тохиож буйтай холбогдуулан түүний амьдрал, бүтээлийн талаар дараа үеийн судлаачдад таниулах зорилго бүхий намтар нийтлэлийг “Нийтлэл” хэсэгтээ хүргэж байна.

Энэхүү дугаарт өгүүллээ нийтлүүлсэн эрдэмтэн судлаачид болон үнэт цаг заваа харамгүй зориулан бодит шүүмжийг ирүүлсэн нийт шинжээч эрдэмтэд болон Редакцын зөвлөлийн гишүүдэд Ерөнхий эрхлэгчийн зүгээс гүн талархал илэрхийлж байгаагаа үүгээр уламжилъя.

“Олон улс судлал” сэтгүүлийн 2025 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүллээ хэвлүүлэх хүсэлтэй эрдэмтэн судлаач Та бүхэн <https://mongolijol.info/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээж болохын зэрэгцээ сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ mjis@mas.ac.mn цахим шуудангаар ирүүлбэл бид хэзээд талархан хүлээн авах болно.

*Ерөнхий эрхлэгч
Дашиямын Золбоо*

*Нарийн бичгийн дарга
Болдын Хишигжаргал*